26

# Б Н М А У

## УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

92 оны 6 сарын 25 — № 166. — Улаанбаатар хот

Барааны зах /УҮТ/ байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Монгол улсын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Улаанбаатар хотын Захын конторыг Барааны зах /УҮТ/ болгон зохион байгуулж 1992 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн ажиллуулсугай.

2. Барааны захын ажиллагсдын цалингийн жишгийг тогтоож өгөхыг Санхүүгийн газар /Н.Тонгор/-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1987 оны 4 дүгээр сарын ...-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дүгээр заалт, Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 297 дугаар тогтоолын 3 дугаар заалт, мөн ...ын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 113 дугаар тогтоолын 9 дүгээр зүйлийн "а" заалтыг тус хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА — Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА — Ц.БОЛДСАЙХАН